

ЮАНЬ ШИ КАЙН ӨВӨР МОНГОЛД АВСАН
ТӨРИЙН БОДЛОГО ХИЙГЭЭД “МОНГОЛ ЕР ҮГИЙН СЭТГҮҮЛ”

Оюун*

* Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн дэд профессор, докторант
Хөрвүүлсэн Л.Норовсүрэн

Түлхүүр үг: төрийн бодлого, Учангийн бослого, Монголыг тохиолдуулан харгазах зүйл дүрэм, хамт найралдах, чулуун барын арга.

Манж Чин улсад 1911 оны 10-р сард Учангийн бослого үүсч, цагагчин гахай жилийн хувьсгал (1)-ын хөшгийг ярсан байна. Тус жилийн 12-р сарын 28-нд Ар Монгол Оросын дэмжлэгтэйгээр Их Монгол хаант улсыг байгуулж, Жавзандамба хутагтыг хаан ор суулгаж, оны цолоо “олноо өргөгдсөн” хэмээж, тусгаар тогтносноо тунхаглав.

Ар Монголын тусгаар тогтнолыг дагалдан Өвөр Монгол оронд ч Хөлөнбуйрын тусгаар тогтнол ба Утайгийн сэдсэн “Зүүн Монголын тусгаар тогтнол” хэмээн үүсч үймээн дэгдсэний хамт саяхан байгуулагдсан Иргэн улсын засгийн газарт монголчууд ээдрээ мадагтай байсан болохоор Бээжингийн засгийн ордон (2)-оос “Монгол ер үгийн сэтгүүл” эрхэлж хамт найралдах ёсыг ухуулахын хамт Монгол оронд авсан төрийн бодлогоо сурталчилсан байна.

Нэг. Юань Ши Кайн Өвөр Монголд авсан төрийн бодлого

1912 оны 3-р сард Юань Ши Кай Дундад иргэн улсын түр цагийн Ерөнхийлөгч болж Бээжингийн засгийн ордон иргэн улсыг ноёрхсон 15 жилийг эхлүүлсэн юм. Энэ цаг үед Ар Монгол тусгаар тогтнож, Өвөр Монголын нэг хэсэг нь аялдан дагаж тусгаар тогтнох үймээн дэгдэж байсан болохоор улс төрийн байдлыг тогтоон байлгахын төлөө Юань Ши Кай Өвөр Монгол оронд хоёр төрийн бодлогыг явуулсан байна. Нэг нь “Монголыг тохиолдуулан харгалзах зүйл дүрэм” гэдгийг нийтэлж монгол ван, гүн, язгууртныг илбэн татсан, нөгөө нь засаг захиргааны эзэмдлээ чангатгаж, онцгой орон гарган, монголчууд төвлөрсөн газар орныг салган эзэмджээ.

Ар Монголын тусгаар тогтнол нь Оросын дэмжлэгээр явагдсан болохоор Бээжингийн засгийн ордон урьдаар Өвөр Монголыг тогтоон авч, дараа нь Ар Монголын асуудлыг шийдвэрлэх бодлого авсан юм. Ар Монголын тусгаар тогтносон байдал Өвөр Монголд үүсэхээс сэргийлэхийн төлөө Иргэн улсын

тэргүүн он (1912)-ы 8-р сарын 1-нд Бээжингийн засгийн ордноос "Монголыг тохиолдуулан харгалзах зүйл дүрэм"-ийг нийтэлжээ. Энэ тогтоолын гол агуулга нь: "Олон монгол ван, гүнгийн уг бүхий захиран засах эрхийг нэгэн адил хуучин ёсоор байлгамой. Дотоод гадаад монгол хан, ван, гүн, тайж үеийн хэргэм, олон суурь цолыг мөн хуучин ёсоор залгамжилж, түүний уул хошуундаа эдэлж бүхий онцгой эрхийг бас ч хуучин ёсоор болгож өөртүүлэхгүй, Монголын олон газрын хутагт лам нарын үг бүхий өргөмжлөл цолыг цөм түүний хуучин ёсоор болгомой. Ван гүнгийн үе улирах хэргэмийн цалин пүнлүүг зүй нь эрхэмлэн өгмүй. Монгол хүний нанхиад бичиг нэвтэрхий мэдэх ба жич хэр хэмжээ тогтоосон цагаач лугаа нийцсэнийг нийслэл бөгөөд гаднах бичиг цэргийн эл тушаалыг хүлээлгэн хэрэгсэж болмой"¹.

Тус жилийн 9-р сарын 20-нд Юань Ши Кай бас "хамт найралдахыг зөвшөөрөн дагасан эл засаг ван гүнд зэрэг хэргэм нэмэх" зарлиг буулгаснаас харчин ван Гүнсээноров, хорчин ван Амарлингуй, Ар Монголын ван Наянтай зэрэг маш олон монгол ван, гүн нарын зэрэг хэргэм нэмэгдсэн мөртөө ван гүн засагт үл багтах язгууртны давхаргын хүмүүс ч хамт найралдах ёсыг цуурайтан дагаснаар үе улирах зэрэг хэргэм олсон байна².

1912 он болон 1913 онд Зүүн Монгол ба Баруун Монголын ван, гүнгийн хурлыг хуралдуулж, хатуу зөөлөн аргаар хэдэн зүйлийг зөвлөн тогтоосон байна. Түүний гол агуулга нь: Монголын ван гүн Ар Монгол тусгаар тогтнохыг эсэргүүцэж байгаагаа илэрхийлж, хамт найралдах

улс төрийн тогтоцыг хүрээлдэг л юм бол засгийн ордноос монгол ван, гүнгийн уулын онц эрхийг батална гэсэн байна. Юань Ши Кайн засгийн ордноос бас Өвөр Монголын урвалгаанд оролцсон ван, гүн, дээд давхрагатаан ба хошууны ардууд хэрэв сэтгэл эргэж буцан ирвэл уулын эд хөрөнгийг нь ёсоор эдлүүлж өнгөрснийг нэхэмжлэхгүй. Уул нь хөрөнгөгүй хүмүүсийг ч тохитой тохируулж аж амьдралтай болгоно гэсэн байна. Ингээд Ар Монголд дутаасан Өвөр Монголын ван, гүн, дээд давхаргатадын цөөхөн хэд нь хүрээд үлдсэнийг гаргавал олонх нь 1915 оноос хойш Юань Ши Кайн засгийн ордныг дагаж, буцаж ирсэн Удай, Хай Шан мэтийн хүмүүс ч уулын зэрэг хэргэмээ сэргээсэн байна³.

Юань Ши Кай дээрх аргаар Өвөр Монголын ван гүн, дээд давхаргатадыг илбэн татсанаас монгол ван, гүн нар залгаа залгаагаар Юань Ши Кайг дагана гэдгээ илэрхийлж, хамт найралдахыг хүрээлж, Өвөр Монгол орон үндсэндээ тогтуун болсон юм. Юань Ши Кайгийн Өвөр Монголд авсан нөгөө нэг бодлого бол Өвөр Монголын эл чуулган хошуу дахь эзэмдлээ чангатгасан явдал болно. Даруй Бээжинд Монгол-Төвдийн хэрэг явдлыг шийтгэх яам (3) гаргаж тусгайлан Монгол-төвдийн хэрэг учрыг шийтгүүлж, харчин ван Гүнсээноровыг захирлаар томилсоны⁴ хамт Хөлөнбуйрыг Хармөрөн мужид, Жирмийг Гирин мужид тус тус захируулсан бөгөөд Өвөр Монголд Сүй Юэн (4), Пе Хе (5), Цахар (6) гурван онцгой орон гаргаж, монголчуудыг салган захирсан байна. Ингээд Өвөр Монголын эл чуулган хошуунууд цөм эл

муж онцгой орнуудад хуваарилагдан орж, Өвөр Монгол гэсэн монголчуудын төвлөрөн суурьшсан газар орон салгагдсан юм.

Хоёр. "Монгол ер үгийн сэтгүүл"-ийн тухай

"Монгол ер үгийн сэтгүүл"-ийг 1913 оны 1-р сард Монгол-Төвдийн хэрэг явдлыг шийтгэх яам эрхлэн гаргаж 1914 оны 6-р сард "Дотоод журганыг сайхан болгон халахын учирт" түр хэвлэл зогсож, нийт 18 дугаар гаргажээ (7). Тус сэтгүүлийг 16х23 см-ийн хэмжээтэй, 90-180 хуудастайгаар хятад, монгол хоёр бичгээр хадмаллан, чулуун барын аргаар сар тутам хэвлэж байв. Сэтгүүлийн монгол бичгийн зохиогч Иүй Лиян Шен, зохион орчуулагч Бу Вен Шен, Ли Хан Еин, хуулан орчуулагч Таяажав, Хай Фен Шан⁵ нар байв. Сэтгүүлийн хавтас хээ угалзаар хөвөөлөгдөж, дээд талд нь таван өнгийн иргэн улсын хос далбааг солбицуулан тавьж, сэтгүүлийн нэрийг хятад, монгол хоёр бичгээр төв дунд нь байршуулж, баруун талд хэвлэсэн он, сар ба дугаарыг тавьжээ.

Тус сэтгүүл улс төрийн шаардлагаас болж төлбөргүйгээр Бээжинд суугаа ван, гүн, Ар, Өвөр Монгол, Сүй Юэн, Ре Хе, Цахарт нийт 21812 дэвтэр тархаагджээ. Энэ сэтгүүл 1915 оны 4-р сард хэвлэл

сэргэж нэрийг "Монгол утгын сэтгүүл" хэмээн сэтгүүлийг дахин дугаарлажээ. 1916 оны 6-р сард хэвлэл зогсож, нийт 15 дугаар гаргажээ⁶.

"Монгол ер үгийн сэтгүүл"-д "Зураг зурмал", "Цааз зарлал", "Шүүмжлэл өгүүлэл", "Чухал сонсгол", "Өчих асуух", "Албан бичиг", "Тусгай зүйл", "Бага үлгэр", "Элдэв зүйл" зэрэг байнгын булантай байжээ. 7, 10 дугаарт нь

«
"Монгол ер үгийн сэтгүүл"-ийг 1913 оны 1-р сард Монгол-Төвдийн хэрэг явдлыг шийтгэх яам эрхлэн гаргажээ 1914 оны 6-р сард "Дотоод журганыг сайхан болгон халахын учирт" түр хэвлэл зогсож, нийт 18 дугаар гаргажээ. Тус сэтгүүлийг 16х23 см-ийн хэмжээтэй, 90-180 хуудастайгаар хятад, монгол хоёр бичгээр хадмаллан, чулуун барын аргаар сар тутам хэвлэж байв.

»

"Хоцорсныг нөхөв" булан нэмэгдэж, 17, 18 дугаарт "Сургуулийн өгүүлэл", "Цугларсныг орчуулсан" гэх хоёр булан нэмэгдсэн байдаг. Зохиогчид олдоод байгаа 1-3, 5-18 дугаар дахь "Зураг зурмал"-д нийт 40 хувь зураг нийтэлжээ. Үүнд иргэн улсын Ерөнхийлөгч Юань Ши Кай, Монгол-Төв-

дийн хэрэг шийтгэх яамны захирал Гүнсээноров, Монгол-Төвдийн сургуулийн захирал Да Шеу зэрэг есөн хүний гэрэл зураг, Чан Чунгийн хурал ба Баруун Монголын хурлын хамтын гэрэл зураг, тус сэтгүүлийн хорооны ажилтнуудын хамтын гэрэл зураг, Монгол-Төвдийн сургуулийн бэлтгэл ангийн хамтын гэрэл зураг, Хязгаарыг бодох тэргүүн зэргийн сургуулийн хөх, улаан зэргийн ангийн хамтын гэрэл зураг, жич асар тагтын гэрэл зураг, монгол ван, гүнгийн хувцасны дүрмийн зураг, малгайн тэмдгийн зураг, Иргэн улсын

хуурай замын болон далайн цэргийн далбааны зураг ба "таван угсаа хамт найралдах"-ыг тусгасан агуулгын зургууд буй.

"Цааз зарлал"-д голдуу төр гүрний чухал дүрэм тогтоол, Монгол, Төвдөд холбогдох зарлал ба Иргэн улсын Ерөнхийлөгчийн эл зүйлийн зарлал нийт 323-ыг нийтэлжээ. Үүнд Монголд холбогдох зарлал (таван угсаа хамт найралдах, ван гүн өргөмжлөх дүрэм, Монголын эд хөрөнгийг хамгаалах дүрэм, цэрэг гаргаж Ар Монголтой дайралдах тухай) нийт 16, монгол ван гүн давхаргатнуудад "Бид сэтгэлээр дотогш хандаж, хамт найралдахыг зөвшөөрөн дагасан"-аас зэрэг хэргэм нэмсэн зарлиг нийт 101, Ар Монголыг дагаснаас зэрэг хэргэмээ авахуулсан зарлал 4, хамт найралдахыг зөвшөөрөн дагасан лам, хутагт нарыг өргөмжилсөн зарлал 36 байж, бүх цааз зарлалын 48,6 хувийг эзэлж буй.

"Шүүмжлэл өгүүлэл"-д бурхан шашны тухай, аргын улирлыг халан хэрэглэх тухай, өрсөлдөөний тухай, өөртөө засах ба тусгаар тогтнохын ялгаа, мал малжихыг сайжруулах, Ар хүрээ хувиндаа тулгар төр байгуулсныг шүүмжилсэн, зовлон буяныг өөрөө эрдэг тухай, хамт найралдах тухай, Монголын хурал зөвдөлцөөний тухай, улсын тогтоц хувиравч нутаг дэвсгэр үл хувирах тухай, засгийн ордны чиглэлт, төрийн бодлогын тухай, Монгол, Төвд хүч хамтатган урагш давшиж улсын үндсийг бататгах тухай, Монгол, Төвдийн хязгаарыг бататгах тухай, хэвлэл дармалын гаалийн ашиг хорын тухай, Монгол, Төвдийн жуулчлах багийн тухай шинжлэх ухааны мэдлэгүүдийг өгүүлэн танилцуулсан байна.

"Өчих асуух" буланд голдуу иргэн улсын төрийн тогтоц ба төрийн бодлогын тухай мэдлэгийг асуулт, хариултын хэлбэрээр танилцуулж, монголчуудад улс гүрний үзэлтийг буй болгон, хятад, манж, монгол, хотон, төвд таван угсаа хамт найралдах гэдгээ ухуулж байв.

"Албан бичиг"-т голдуу хамт найралдахыг хүрээлэн дагасан тухай, хагалбарлах үйлийн тухай, монгол тайж, тавнангийн тоог бүртгэх тухай, ван гүн, хутагт нарын жилийн бэлгийн тухай, лам хутагтыг өргөмжлөх тухай, зоорь (уурхай)-ийг нээн уудлах тухай, сүм хийдэд нэр хайрлах тухай, монгол түшмэдийн хувцасны дүрмийн тухай, монгол ван, гүнгийн нийслэлд ирэх жилийн жишээгийн дэс дарааллыг тогтоох тухай, Нийслэлд суусан монгол ван, гүнгийн хүнсэн амууг тогтсон ёсоор өгөх тухай албан бичгүүд нийтлэгдэж байв.

Жич хараат хошууны чухал засгийн тухай Ерөнхийлөгчид өргөсөн бичиг ба Ерөнхийлөгчийн цохолтыг нийтэлжээ.

"Чухал сонсгол"-д Монгол-Төвдийн хэрэг явдлыг шийтгэх яамны тухай, Дундад иргэн улсыг гадаадын улсууд мэдрэн зөвшөөрсөн цахилгаан мэдээнүүд, монгол ван, гүн нар Ар Монголын тусгаар тогтнолыг эсэргүүцэж байгаагаа илтгэж зөвлөлгөөний хуралд санал дэвшүүлсэн тухай, Өвөр Монголд төмөр зам дэвсэх ойрын төлөвлөгөө, зөвлөлгөөний хурлаас Дундад улсын хэлэлцээрийн гэрээг зөвшөөрсөн, "Монгол ер үгийн сэтгүүл"-ийг "Шинэ дундад улс сэтгүүл" шүүмжлэн үнэлсэн, зоорийн

явдлыг магадалсан, Зүүн Монголын ван, гүн Чан Чунд хуралдсан, Монгол-Төвдийн сургуулийн бэлтгэл анги сурлага эрхэлсэн, Ерөнхийлөгч сонгох хурал болсон, Ерөнхийлөгч тушаал хүлээсэн, Хятад, Монголын хурал хуралдсан Засгийн хурал зөвлөлийн хурал нээсэн, эл улсаас Юань Ши Кайд илгээсэн баярын үгс зэрэг том хэрэг учрын тухай мэдээлэл нийтэлжээ.

“Тусгай зүйл” буланд Манж, Монгол Хотонгийн хязгаарыг дотоод явдлын журганд хамтатган захирах тухай, цуурхал үгийг үл сонсон хамт жаргалыг үүсгэн бүтээх тухай, монгол, хотон, төвдийг эрхэмлэн харгалзах зүйл, Монголыг тохиолдуулан харгалзах зүйл дүрэм, улсын хурлыг бодож бэлтгэх газар ба Ши Нин, Хөх нуурын сонгон өргөхийг харгалзан захирагчийн харилцан илгээсэн цахилгаан, монгол ван, гүн Ар Монголыг үл дагах санаагаа улсын явдлын хороонд илгээсэн цахилгаан, Монгол, Төвд жуулчлах баг байгуулах мэдэгдэл ба дүрэм, Монгол-Төвд сургууль байгуулсан тухай ба тус сургуулийн дүрэм хэмжээ, сургуулийн тушаалтнууд ба сургагч түшмэдийн илтгэл, нийслэлд ирсэн ван гүн нарын онцгой замын хүнсний дүрэм зүйл, Монгол, Төвд ван гүн нарын малгайн тэмдгийг халж тогтоох тухай, Монгол-Төвдийн хэрэг явдлыг шийтгэх журганы хэрэг шийтгэх дүрэм ёс зэрэг монголын хэрэг явдлын тухай бичиг материал буюу албан захидлыг нийтэлжээ.

“Элдэв зүйл”-д нам хурлын чухал үйлс, Монгол, Төвдийн онцгой хөрөнгө, аймгаа хамгаалах тухай, шинжлэх ухааныг хэрэглэх учир, “Мод нь их

болбоос үндэс нь гүн” хэмээх өгүүлэл, шашин суртахууны тухай, “Үхэр, морьтэжээх нь”, “Шинэ илрүүлэн гаргасан үсэн хуяг” зэрэг мэдлэг, мэдцийн тухай элдэв зүйлийг нийтэлжээ.

“Бага үлгэр”-т “Тубу Хуй улс байгуулсан үлгэр”, “Түргэнээ толгойгоо эргүүлэх”, “Барс лугаа нөхөрлөсөн гөрөөсний үлгэр”, “Ховдогийг цээрлүүлсэн тэмдэглэл”, “Хүчин хамсахын уг ёс”, “Урддаа бүхий нь эрхэм”, “Монголын өв тэгш чийрэг байсан үеийн ихийг өгүүлмуй”, “Эрдмээр эрдмийг хариулмуй”, “Сэжиглэл цээрлэлийг хичээх”, “Ах дүү гашуудвай”, “Таван аймгийн уг эхийг байцаасан бараг” гэх зэрэг үлгэр буюу өгүүлүүдийг нийтэлж, хятад, манж, монгол, хотон, төвд “таван аймгийн уг эх” нэгтэй болохоор хүчин хамсаж “сэжиглэл цээрлэлийг хичээнэ”, “Эрдмээр эрдмийг хариулах” ба Ар Монгол Оросыг дагасан нь яг “Бар лугаа нөхөрлөсөн гөрөөс” шиг аюултай, тусгаар тогтнохоо больж “түргэн толгойгоо эргүүлэх” хэрэгтэй хэмээх санаагаа уран зохиолын хэлбэрээр ёгтлон гаргаж өгөөдөн шүүмжилсэн байна.

Тус сэтгүүлийн 7, 10 дугаар дахь “Хоцорсныг нөхөв” буланд Иргэн улсын цааз зарлалын бүхий л бичгийг нөхвөрлөн нийтэлжээ. 17, 18 дугаар дахь “Сургуулийн өгүүлэл” буланд шинжлэх ухааны төрөл ангилал хийгээд амь нас, бодис ба сэтгэхүйн ухагдахууныг тайлбарлажээ. “Цугларсныг орчуулсан” буланд Европ, Америкийн сонин сэтгүүл, ном хэвлэлээс орчуулсан зүйлсийг оруулжээ. Үүнд: “Нэгэн улс болоод хүн ард”, “Хүний тэнгэрийн чанар дэмий холгүй”,

“Вашингтоны цэргийн хүнийг энэрэн хөөрхийлөх нь”, “Өндөр эрхэм явдал үйлдэл”, “Хөрөнгө бүтээхийн нягт арга” зэрэг зохиолыг нийтэлжээ.

Үүнээс гадна тус сэтгүүлийн 17 дугаарт хоёр зар нийтэлжээ. Нэг нь Бээжийнгийн Чан Ань зочид буудлын зар, нөгөө нь Шин Чан морин тэрэг үйлдэх газрын зар болно.

Гурав. Дүгнэлт

“Монгол ер үгийн сэтгүүл” нь Иргэн улсын засгийн ордны шууд хараат байгууллага – Монгол-Төвдийн хэрэг учрыг шийтгэх яамны байгууллагын сэтгүүл болсны хувьд хэвлэх тоо нь нэлээд их, тараах хүрээ хэмжээ нь нэлээд өргөн байсны хамт мөнгө төлөхгүй хүргэж өгдөг болохоор нэлээд хэмжээний монголчуудыг нөлөөлж байсан нь дамжиггүй.

1. Тус сэтгүүлийн эл булангийн нийтлэлээс үзвэл Юань Ши Кайн монгол ван, гүн, дээд давхаргатныг илбэн татах бодлогыг гүйцэд сурталчилж, монгол ван, гүн, тайж, язгууртан, гэгээн хутагт нарт зэрэг хэргэм нэмж, эрхэм цол өргөмжилсөн зарлалыг их хэмжээгээр нийтлэхээр дамжуулан Монголыг илбэн татаж, айлган сүрдүүлэх бодлогыг бодитойжуулжээ.

2. Тус сэтгүүл “таван угсаа хамт найралдах” үзэлтээ иргэн улсын “энэрэл журам”-ыг бараг бүх дугаарын эл буланд шингээж, эл зүйлийн нийтлэл ба ухуулгын зургаар шууд буюу далд илтгэн ухуулж, иргэн улсын ноёрхлыг бататгахад зориулагджээ.

3. Уг сэтгүүл хэдийгээр засгийн ордны албан сонины шинжтэй боловч “Элдэв

зүйл”, “Сургуулийн өгүүлэл”, “Цугларсныг орчуулсан”, “Бага үлгэр” дэх нийтлэлүүд нь монголчуудад тухайн үеийн улс төр, нийгмийн байдал ба иргэн улсын засаг хуулийг зохих хэмжээгээр ойлгуулах, мэдээ занги хангах, шинжлэх ухааны мэдлэг олгох ба хүмүүжүүлэн сэнхрүүлж, монголчуудын оюуныг зохих хэмжээгээр нээгдүүлж байсныг үгүйсгэж болохгүй.

4. Анхны үеийн монгол сонины нэгэн болсны хувьд тус сэтгүүл хоёр хувь зар нийтлэхийн хамт нүүрийн хавтсаа гоёлон урлаж, зураг зурмал хавчуулж, гоо сайхан хөвөөлж ороолгосон нь хожмын сонин, сэтгүүл эрхлэгчдэд зар сурталчилгааг чухалчлах ба сонин сэтгүүлийг чимэх талаар дуурайл болох нь лавтай.

Тайлбар:

1. 1911 оны 10-р сарын 10-ны өдөр Учан хот доторх хувьсгалд хэлбийсэн шинэ шинэ цэрэг бослого гаргаж, бүгдийн захирагч сайдын яамыг дайрч, дараа өдөр нь Учанг эзэлжээ. Тус жил бол хуучин улирлын цагаагчин гахай жил байсан болохоор энэ удааны хувьсгалыг цагаагчин гахай жилийн хувьсгал гэдэг. Учангийн бослогын дараа Дундад улсын эл муж залгавар цуурайтан дагаж, дэмий удсангүй хагасаас илүү мужууд тусгаарлахаа тунхаглажээ.

2. Юань Ши Кайн цэргийн эрхтэний бүлгэмийн засгийн ордныг заажээ. Бээжинд нийсэллэсэн болохоор сүүлийн үеийн Нанжингийн засгийн ордонтой ялгахын төлөө ингэж нэрлэдэг.

3. Монгол-Төвдийн хэрэг шийтгэх яамыг Юань Ша Кай Монголын эл чуулган хошуудыг эзэмдэхийн төлөө 1912 оны 5-р сард байгуулж, дотоод журганд хамааруулаад, 7-р сард төрийн явдлын ерөнхий сайдад харьяалуулж, 1914 оны 5-р сард Ерөнхийлөгчид шууд хамаарагдах болгосон юм.

4. Сүй Юэн онцгой орныг 1914 оны 1-р сард байгуулж, Хүй Сүй Ду-гийн 12 саян,

Түмэдийн 2 хошуу, Улаанцав ба Их зуу чуулганыг харьяалуулав.

5. Ре Хэ онцгой орныг 1914 оны 2-р сард байгуулж, Ре Хе Ду ба Зост, Зуу од хоёр чуулганыг харьяалуулав.

7. Цахар онцгой орныг 1914 оны 3-р сард байгуулж, Шин Хэ Ду, Шилийн голын чуулган, Цахар зүүн, баруун гарын найман хошууг харьяалуулав.

8. Зохиогч тус жилийн 5-р сард Бээжингийн номын сангаас "Монгол ер үгийн сэтгүүл"-ийн 2-3, 5-18 дугаарыг гэрэл зургаар буулган авсан бөгөөд нэгдүгээрийг нь Өвөр Монголын номын сангийн судлагч Түймэр гуай харамгүй хангажээ.

Ишлэл

¹ "Монгол ер үгийн сэтгүүл". 1913, №1.

² Г о В е й М и н. 2006. Чимиддорж эрхлэн найруулав. "Өвөр Монголын нэвтэрхий түүхийн хөтөлбөр". Ардын хэвлэлийн хороо.

³ Г о В е й М и н эрхлэн найруулав. 1992. "Өвөр Монголын ойр үеийн хураангуй

түүх". Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

⁴ "Монгол ер үгийн сэтгүүл". 1913, №1.

⁵ "Монгол ер үгийн сэтгүүл". 1914, №18.

⁶ Т ү й м э р. 2002. Иргэн улсын эхний үеийн "Монгол ер үгийн сэтгүүл" ба "Монгол утгын сэтгүүл". Өвөр Монголын Багшийн Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, №1.

Резюме

В данной статье автор, опираясь на первоисточники, на основании многочисленных документальных фактов излагает политику умиротворения Внешней и Внутренней Монголии, проводимую правительством Китайской республики. При этом большое внимание уделялось публикационной политике прессы, в частности журнала "Монгол ер үгийн сэтгүүл", который способствовал ликвидации независимости Внешней Монголии.